


БУАГАН, ЦАЦРАЛ ХОЁР НИЙГМИЙН ДААТГАЛТАЙ ТАНИЛЦСАН НЬ

(Оюутан, сурагчдад зориулав)



УЛААНБААТАР 2016



ОУХБ Япон улсын
олон/хоёр талт хамтын
ажиллагааны хөтөлбөр



Нийгмийн даатгалын
ерөнхий газар



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага

Өмнөх үг

Эх орныхоо өнцөг булан бүрт эрдэмд шамдан суралцаж буй оюутан, сурагчид та бүхэн нэг л өдөр хөдөлмөрийн зах зээлд хөл тавьж, зорилго тэмүүлэлдээ хүрэхэд дахин нэг алхам ойртох болно.

Залуус та бүхэн хүсэл мөрөөдлөө биелүүлж, тавьсан зорилгодоо хүрэхийн тулд ирээдүйгээ зөв төлөвлөж, тохиолдох эрсдэлийг даван туулах бэлтгэлтэй болох нь чухал юм. Үүний тулд таньж мэдвэл зохих олон зүйл байгаагийн нэг нь яах аргагүй “НИЙГМИЙН ДААТГАЛ” мөн.

Хүний амьдралын туршид жам ёсны болон гэнэтийн байдлаар тохиолддог нийгмийн шинжтэй эрсдэлийн үед даатгуулагчийг хамгаалж, орлогын баталгааг нь хангахад нийгмийн даатгал чухал ач холбогдолтой. Оюутан, сурагчид та бүхэн нийгмийн даатгалын нэг төрөл болох эрүүл мэндийн даатгалд даатгуулж, ач тусыг нь хүртэж байсан гэдэгт эргэлзэхгүй байна.

Та энэхүү номоор Булган, Цацрал хоёртой хамтдаа аялж, нийгмийн даатгал болон түүний ач холбогдлын талаар илүү ихийг мэдэж аварай.


Хүсэл мөрөөдөлтэй, зорилго тэмүүлэлтэй залуус та бүхэндээ амжилт хүсье!



Өвөө: Тэтгэвэрт
Эмээ: Тэтгэвэрт
Аав: Хувиараа хөдөлмөр эрхлэгч
Ээж: Цэцэрлэгийн багш
Дүү Цацрал: Дунд сургуулийн сурагч
Дүү Төгс: Хоёр настай

Сайн байцгаана уу,
найзуудаа?
Намайг Булган
гэдэг. Би удахгүй их
сургуулиа төгсөж
инженер болно. Хурдхан
л мэргэжлээрээ
ажиллахыг хүсч байна.
Намайг амжилтанд
хүрвэл гэр бүлийнхэн
маань ямар их бахархах
болоо.






Би яагаад инженер болохоор шийдсэн гээч....
Насаараа инженер хийсэн өвөө маань л
нөлөөлсөн байх. Одоо өвөө маань тэтгэвэртээ
гарчихсан ч гэсэн залуугийнх шигээ л бүтээлч
хэвээрээ. Нээрээ өвөө тэтгэврээ авлаа гэж
байсан. Ингэхэд өвөөд хэн тэтгэвэр өгдөг юм
бол? Цацаа чи мэдэх үү?



Мэдэхгүй ээ, ахаа.
Өвөө танд хэн тэтгэвэр
өгдөг юм бэ?



Өвөө
нь ажил хийж
байхдаа нийгмийн даатгалд
хамрагдаж тэтгэвэр авах бэлтгэлээ
хангачихсан гэх үү дээ. Одоо
нийгмийн даатгалын байгууллагаас
өвөөгийнх нь тэтгэврийг банкаар
дамжуулж өгдөг юм.




Нийгмийн даатгал гэж юу юм бэ?



Хамгийн товчоор хэлбэл, хүмүүс тодорхой шалтгааны улмаас ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй болж, орлого олж чадахгүй болсон үед алдсан орлогыг нь тодорхой хэмжээнд нөхөн олгож, орлогын баталгааг нь хангадаг юм.


Би сайн ойлгосонгүй, өвөө.

Жишээ нь, өвөө нь одоо өндөр настай болсон, ажил хийж чадахгүй. Гэтэл хоол хүнс авах, байр, гэрлийн мөнгөө өгөх гээд мөнгөний хэрэгцээ тасрахгүй байдаг. Өвөө нь нийгмийн даатгалд олон жил шимтгэл төлсний ачаар өнөөдөр тэтгэвэр аваад санаа амар явж байна. Энэ чинь л нийгмийн хамгаалал шүү дээ.



Манайд бас даатгалын талаар товч мэдлэг олгох хичээл орж байсан. Хүний амьдралд тохиолдох янз бүрийн эрсдэлээс хамгаалах, тэдгээрээс учрах хохирлыг бууруулах зорилгоор олон төрлийн даатгал үүсч хөгжсөн гэж багш ярьж байсныг санаж байна. Нийгмийн даатгал бас л адилхан биз дээ.

Тиймээ, хүү минь. Нийгмийн даатгал гэхээр хөгшчүүл бидний тэтгэвэр л гэж ойлгож болохгүй. Нийгмийн даатгалын хувьд өндөр наслахаас гадна өвчлөх, ажилгүй болох, хөдөлмөрийн чадвараа алдах, нас барах, тэжээгчээ алдах, жирэмслэх, хүүхэд төрүүлэх зэрэг тохиолдлууд бас хамрагддаг.






Би ч
гэсэн нийгмийн даатгалын ач
тусыг хүртээд л байгаа. Өнгөрсөн жил аав
нь ажил дээрээ хөлөө бэртээгээд 2 сар шахуу
хэвтсэнийг санаж байна уу. Энэ 2 сарын хугацаанд би
нийгмийн даатгалаас тэтгэмж аваад зогсохгүй эрүүл
мэндийн даатгалаас эмчилгээний зардал авч байсан.
Хэрэв би нийгмийн даатгалд даатгуулаагүй байсан бол яах
байсныг та хоёр бодоод үз л дээ.
Гутлаа засахгүй юм чинь ямар ч мөнгө олохгүй л гэсэн
үг. Тэгэхээр бид нарын өдөр бүр идэж уух юм, та хоёрын
автобусны мөнгө, байр, гэрлийн мөнгийг ээж нь л ганцаараа
төлөх болно биздээ.



Аан. Тэгвэл би ажилтай болмогцоо нийгмийн
даатгалын тухай бодох хэрэгтэй юм байна.

Өвөө шиг настай болсон хойноо авах
тэтгэврээ өнөөдөр бодох хэрэгтэй гэж үү?

Тэгэлгүй яахав. Өвөө нь Булган ах шиг чинь залуу байхаасаа
нийгмийн даатгалд шимтгэл төлж байсны хүчинд өнөөдөр
боломжийн тэтгэвэртэй байна шүү дээ. Аав нь ч бас насаа
болохоор тэтгэврээ тогтоолгоод авна. Гэхдээ энэ чинь дан
ганц тэтгэвэртэй холбоотой зүйл биш гэж өвөө нь түрүүн
хэлсэндээ.





Өвөө нь 40 гаруй жил ажиллаад тэтгэвэрт гарсан. Энэ хугацаанд нийгмийн даатгалд цалингаасаа сар бүр шимтгэл төлж байсан. Бас нийгмийн даатгалын ач тусыг янз бүрээр л хүртэж ирлээ. Сайхан л байдаг юм.

Мэддэг хүмүүсийн ярих нь нийгмийн даатгал хамгийн сайн хамгаалалт, баталгаа гэдэг юм билээ. Нийгмийн даатгалгүй зарим улс оронд иргэд нь өвдөх, бэртэж гэмтэх, өндөр наслах, ажилгүй болох, хүүхэд төрүүлэх зэрэг тохиолдолд ямар ч орлогогүй, хэцүү л байдаг юм гэнэ лээ. Манай улс энэ тал дээр тун гайгүй орны тоонд ордог гэсэн шүү.

Тэгвэл өвөө маань нийгмийн даатгалд овоо их мөнгө төлж дээ.

Уул нь
гайгүй шүү. Сар бүр
цалин, хөдөлмөрийн
хөлснийхөө 10 хувьтай
тэнцэх шимтгэл төлнө.
Нийгмийн даатгалаас
эргүүлээд авч байгаа нь
түүнээс чинь хэд дахин их
болно. Жишээлбэл, өвөө нь
нэлээд олон жил төлсөн
шимтгэлтэйгээ тэнцэх
тэтгэврийг нэг жилд авч
байгаа байх шүү. Тийм
үү, аав аа?



За бараг л тийм байх. Түмний буяныг
хүртээд сайхан л байна.



Өвөө та төлсөн шимтгэлээсээ хэд дахин их
тэтгэвэр авдаг юм бол зөрүүг нь хаанаас
өгдөг юм бэ?

Миний ойлгосноор, ажил хийж буй хүн бүр л нийгмийн даатгалд хамрагдаж шимтгэл төлж байгаа. Зарим нь өвөө шиг нь тэтгэвэртээ гарчихсан. Харин нас нь болоогүй шимтгэлээ төлөөд явж байгаа залуу хүмүүс бүр ч олон байгаа. Тэдний төлсөн шимтгэл нь үндсэндээ бидний тэтгэврийн мөнгийг бүрдүүлж байгаа юм шүү дээ.


Илүү нарийн зүйл мэдье гэвэл нийгмийн даатгалын ажилтанд хандахгүй юу, миний хүүхдүүд. Манай дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс эндээс ойрхон байна шүү дээ.

Ер нь энэ талаар жаахан мэдлэгтэй болъё.
Цацралаа хоёулаа явах уу?

Тэгье, би ч гэсэн жаахан юм мэдэж аваад ангийнхандаа ярьж өгье.



Булган, Цацрал хоёр
Нийгмийн даатгалын
хэлтэст





Та хоёр хэнтэй уулзахаар, ямар хэргээр явж байна вэ?

Сайн байна уу, ах аа? Бид хоёр хэнтэй уулзахаа мэдэхгүй байна аа. Уг нь нийгмийн даатгалын талаар мэдээлэл авах гэсэн юм?

Аан, тэгвэл та хоёр 05 тоот өрөөнд манай мэдээллийн ажилтантай уулздаа.


Сайн байцгаана уу, хүүхдүүд ээ? Би та нарт юугаар туслах вэ?

Сайн байна уу, эгчээ?
Бид хоёр нийгмийн даатгалын талаар мэдээлэл авч, ойлголттой болох гэсэн юм. Та бидэнд туслаач.

Бололгүй яахав, 3-уулаа юунаас эхлэх билээ?

Бид 2 гэрийнхэнтэйгээ нийгмийн даатгалын талаар ярилцаж байсан чинь өвөө нийгмийн даатгалд төлсөн шимтгэлээсээ хамаагүй их тэтгэвэр авдаг гэж ярьсан юм. Тэгээд л бид хоёр түүний учрыг олж, илүү нарийн юм мэдэж авахаар танайхыг зорьж ирлээ.






Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө нь үндсэндээ даатгуулагч болон ажил олгогчийн төлсөн шимтгэлээс бүрддэг юм. Жишээ нь, сургуульд ажилладаг багш хүн байлаа гэхэд даатгуулагч нь багш өөрөө, сургууль нь ажил олгогч. Даатгуулагчаас гадна, ажил олгогч нь бас шимтгэл төлнө. Ажил олгогч ажилтны төлсөн шимтгэлээр бүрдсэн сан хангалттай биш бол Засгийн газар улсын төсвөөс нэмж санхүүжилт өгдөг, мөн хүн амын зарим бүлгийн нийгмийн даатгалын шимтгэлийг төлдөг юм.

Манай аав шиг хувиараа ажилладаг хүн яах вэ?

Нийгмийн даатгалд албан журмаар, сайн дураар гэсэн 2 хэлбэрийн аль нэгээр нь даатгуулдаг юм. Албан журмаар гэдэг нь заавал даатгуулах үүрэгтэй гэсэн үг л дээ. Аль нэг газарт цалин хөлстэй ажиллаж байгаа бол албан журмаар, харин хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа бол сайн дураар даатгуулна. Мөн хүсвэл оюутнууд ч бас сайн дураар даатгуулж болно.



Албан журмаар даатгуулсан ажилтан ажил олгогчтойгоо хамтдаа, харин сайн дураараа даатгуулсан хүн ганцаараа шимтгэл төлдөг гэсэн үг үү?

Яг зөв. Нийгмийн даатгалын 5 төрлийн сан байдаг юм. Албан журмаар даатгуулж байгаа бол ажилтан энэ 5 төрлийн санд цалин хөлснийхөө нийт дүнгийн 10 хувиар, ажил олгогч нь 10-13 хувиар шимтгэл төлнө. Та хоёр нийгмийн даатгалын төрөл, тэдгээрээс олгох тэтгэвэр, тэтгэмж, зардлыг энэ хүснэгтээс хардаа.

№	Нийгмийн даатгалын төрөл	Тэтгэвэр, тэтгэмж болон тусламж, үйлчилгээний төрөл
1	Тэтгэврийн даатгал	Өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр
2	Тэтгэмжийн даатгал	Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж
3	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал	Тэтгэвэр (тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр) Тэтгэмж (хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж) Нөхөн сэргээх төлбөр, урьдчилан сэргийлэх зардал, сувиллын зардал
4	Ажилгүйдлийн даатгал	Ажилгүйдлийн тэтгэмж, мэргэжил олгох болон давтан сургалтын төлбөр
5	Эрүүл мэндийн даатгал	Эмнэлгийн тусламж үйлчилгээ, сувиллын тусламж үйлчилгээ, эмийн үнийн хөнгөлөлт



Харин сайн дураар даатгуулж байгаа бол тэтгэврийн, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал гэсэн 3 төрлийн санд нийтдээ 12 хувиар шимтгэл төлнө.

Шимтгэл төлөх орлогынхоо хэмжээг сайн дурын даатгуулагч өөрөө сонгох бөгөөд тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байх ёстой. Нийгмийн даатгалын төрлүүдээс эрүүл мэндийн даатгал арай өвөрмөц. Яагаад гэвэл ажилтай, ажилгүй бүх хүн, хүүхэд ч албан журмаар энэ даатгалд хамрагдана. Хүүхэд, ахмад настны эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төр хариуцдаг. Засгийн газар өмнөөс нь төлнө гэсэн үг.



Аав
ажил олгогчгүй,
ганцаараа ажилладаг
болохоор сайн дураар,
харин ээж албан
журмаар даатгуулсан
юм байна.





Манайх тэгвэл гэр бүлээрээ нийгмийн даатгалтай холбоотой юм байна шүү дээ. Нэг талаас бүгдээрээ даатгуулагч, нөгөө талаас бүгд л янз бүрийн байдлаар үр шимийг нь хүртдэг юм байна. Удахгүй хоёр нас хүрэх жаахан дүү маань хүртэл эрүүл мэндийн даатгалд хамрагдсан юм байна шүү дээ.

Харин тиймээ. Дүү ч гэсэн өвдвөл эрүүл мэндийн даатгалаас эмчилгээний зардал, эмийн хөнгөлөлт авах юм байна.

Хүүхдээ хоёр нас хүртэл нь харж байгаа ээжүүдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг ч мөн төрөөс хариуцаж байгаа. Цацрал чинийх ч бас адилхан.

Өвөө, эмээ, хоёр дүүгийн маань эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төр төлнө гэдэг манай гэрийнхэнд том хөнгөлөлт юм даа. Аав, ээж бид гурав өөрсдөө шимтгэлээ төлчихнө. Бидний хэн нэг маань өвдвөл эрүүл мэндийн даатгалын сангаас тусламж, үйлчилгээ, эм, тарианыхаа зардлыг авчихна. Манайхаас зардал бага гарах юм байна. Нийгмийн даатгал хүмүүсийг ингэж хамгаалдаг байх нь. Эрүүл мэндийн даатгалаас төлдөг зардлын хэмжээтэй энэ хүснэгтийг гар утсандаа авчихъя. Хэрэгтэй юм байна.



Эрүүл мэндийн даатгалаас хариуцах төлбөр (төгрөг)

Тусламж, үйлчилгээний төрөл	Эрүүл мэндийн даатгалын гэрээ байгуулсан:	
	Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага	Хувийн өмчийн эрүүл мэндийн байгууллага
Хэвтүүлэн эмчлэх	145 500 - 804 090	84 875 - 469 052
Өдрөөр эмчлэх	65 475 - 158 895	-
Амбулаторийн үйлчилгээ	15 000 - 16 200	-
Нөхөн сэргээх эмчилгээ	110 000 - 116 281	110 000 - 116 281
Оношилгоо, шинжилгээ	55 000	-
Уламжлалт эмчилгээ	117 000	117 000
Хөнгөвчлөх үйлчилгээ	300 000	175 000
Хорт хавдрын хөнгөвчлөх үйлчилгээ	300 000	-
Хорт хавдрын химийн өдрийн эмчилгээ (тохиолдолд)	450 000	-
Хорт хавдрын туяаны өдрийн эмчилгээ (өдөрт)	66 000	-
Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, хиймэл цорго, протез, ортопедийн үнэ	975 - 28 740 750	-
Эмийн үнийн хөнгөлөлт	Өрх, сум, баг, аймаг, дүүргийн амбулаторийн төрөлжсөн мэргэжлийн эмчийн бичсэн жороор эрүүл мэндийн даатгалын гэрээ бүхий эмийн сангаас авах 183 нэр төрлийн 817 эмийн үнийн 40-80 хувийг буюу 500-65 000 төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлнө.	

* Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн оюутан суралцагч эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх бөгөөд 2016 онд сард 1920, жилд 23040 төгрөг төлөхөөр Засгийн газар тогтоосон байна.

** Даатгуулагч нь эрүүл мэндийн даатгалын сангаас жилдээ 2 000 000 хүртэл төгрөгийн зардлын төлбөрийг төлүүлэх боломжтой.

*** Даатгуулагчийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөр нь тухайн жилийн дээд хязгаар 2 000 000 төгрөгөөс хэтэрсэн тохиолдолд гэр бүлийн өөр нэг даатгуулагч-гишүүний зөвшөөрснөөр, түүний зардлаас жилд нэг удаа шилжүүлэн тооцуулах эрхтэй.




Ингээд тантай ярилцсаны дараа бодоход өмнө анзаараагүй олон юмны учир тайлагдаж байна. Ээж жирэмсэн байхдаа тэтгэмжээ авлаа гээд дүүд хөөрхөн өлгий, живх, бас бусад зүйл авч байсныг ахаа та санаж байна уу?

Тиймээ, санаж байна. Ээж дүүг маань төрүүлэхдээ хэсэг хугацаанд ажлаа хийх боломжгүй болсон учраас тэтгэмжийн даатгалын сангаас "жирэмсний болон амаржсаны тэтгэмж" олгосон юм байна. Чи бид хоёрыг төрүүлэхэд ч бас тэтгэмж авсан байх.

Чи маш зөв ойлгосон байна. Ээж нь ямар ажил хийдэг билээ?

Цэцэрлэгийн багш

Ахаан, албан журмаар даатгуулагч юм байна. Тэгвэл ээж чинь жирэмсний чөлөөгөө авахаас өмнө 12 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 6 сард нь тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн байх юм бол нийтдээ 4 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг төрөхийн өмнө болон төрсний дараа хоёр хувааж авна. Энэ нь ээж нарыг хүүхдээ эрүүл саруул төрүүлэх, төрсний дараа биеэ тэнхрүүлэхэд нь зориулагдсан чухал тэтгэмж шүү.



Ингэхэд дээр таны харуулсан хүснэгтэд байсан олон төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ үүнтэй адилхан уу?

Үгүй. Даатгалын төрөл тус бүрт хамрагдах тохиолдол, учрах эрсдэлийн онцлогоос хамаараад шимтгэл төлсөн байх хугацаа болон олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ өөр өөр байгаа. Тухайлбал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд даатгуулсан хүн ажил үүргээ гүйцэтгэж яваад бэртэж гэмтэн хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд ямар хугацаанд шимтгэл төлснийг нь үл харгалзан тэтгэвэр, тэтгэмж тогтоож олгоно. Гэтэл өндөр насны бүрэн тэтгэвэр авах эрхтэй болохын тулд наад зах нь 20 жил шимтгэл төлсөн байх шаардлагатай байдаг. Өндөр насны тэтгэврийн хувьд эрэгтэй даатгуулагч 60 насанд, эмэгтэй нь 55 насанд хүрсэн байх зэрэг бусад нөхцөл, болзол бас тавигддаг.

Аав маань ноднин ажил дээрээ хөлөө гэмтээгээд эмнэлэгт хэвтээд, дараа нь гэртээ бас хэд хоног байсан юм. Тэр үед тэтгэмж авч байсан. Үйлдвэрлэлийн ослын даатгалын сангаас л авсан юм байхдаа.

Мэдээллийн ажилтан: Ажил дээрээ бэртсэн бол тийм байх. Ийм тохиолдолд даатгуулагчид цалин хөлс буюу шимтгэл төлж буй орлогыг нь 100 хувь нөхөх тэтгэмж олгодог.

Бид даатгуулагчиддаа зориулаад мэдээлэл, танилцуулга бэлдсэн байдаг юм. Та хоёр авч яваад танилцаж болно. Гэрийнхэндээ ч бас үзүүлээрэй.




Цацрал:
Манайхан
нийгмийн даатгалд
хамрагдсаны ачаар таны
тайлбарласан тохиолдлуудад
орлогоо алдахгүй байгаа
юм байна.

Булган:
Тиймээ, дүү минь.
Би ч бас нийгмийн даатгал
хүний амьдралд ямар ач
холбогдолтой болохыг ойлгож
авлаа. Гэхдээ би дахиад нэг
юм асууж болох уу?

Мэдээллийн ажилтан: Болно болно.

Би нийгмийн даатгалыг арилжааны бусад даатгалтай л адилхан гэж бодож байсан. Бас их өвөрмөц юмаа?




Үндсэндээ сая бид гурвын ярианд гол ялгаанууд нь гарсан. Би яриагаа дүгнэх байдлаар зарим жишээ аваад та хоёрт товчхон тайлбарлаж өгье.

- Нийгмийн даатгал нь хүний амьдралын мөчлөг бүрт жам ёсны болоод гэнэтийн байдлаар тохиолддог эрсдэлийн үед үр ашигтай цогц хамгаалалт бүрдүүлж чаддаг.
- Нэг талаас иргэддээ үзүүлж буй төрийн үйлчилгээ, нөгөө талаас албан журмын буюу заавал даатгалын хэлбэрээр голчлон хэрэгждэг тул нийгмээ ч, хувь хүнийг ч давхар хамгаалдаг арга юм. Жишээ нь, өвчлөх, бэртэх гэмтэх бол хамгийн түгээмэл тохиолддог эрсдэл. Тэр болгонд л хүмүүс эрүүл мэндээрээ болон санхүүгийн хохирол хүлээж байдаг. Жилд ханиад томуу мэтийн өвчнөөр хүн хэд хэдэн удаа өвдөж байна. Нэг гэр бүлийнхэн зөвхөн энэ өвчнийг эмчлүүлэхэд зарцуулсан зардал, за тэгээд дээр нь ажлаа хийхгүй алдсан орлогоо тооцвол ч их дүн гарах байх. Улс орны хэмжээнд бол бүр их гарч таарна. Эрүүл мэндийн даатгалгүй хүнд энэ их зардал маш их дарамт болно. Зарим нь шаардлагатай эм, эмчилгээ, үйлчилгээгээ авч чадахгүй бол амь насаа ч алдаж ч болзошгүй. Тиймээс л бүх хүнийг эрүүл мэндийн даатгалд албан журмаар даатгуулж, хүүхдүүд, ахмад настнууд болон тусламж, дэмжлэг шаардлагатай хүмүүсийн даатгалын шимтгэлийг нь төрөөс төлж, эмчилгээ, үйлчилгээ авах боломжийг нь хангаж байгаа юм шүү дээ.
- Өнөөдөр ажил эрхэлж буй хүмүүсийн олонх нь нийгмийн даатгалд шимтгэл төлж байна. Сайн дураараа даатгуулж байгаа хүмүүс ч нэмэгдэж байна. Энэ хэрээрээ тэтгэврийн насанд хүрсэн ахмадуудын дийлэнх олонх нь нийгмийн даатгалаас тэтгэвэр авч, баталгаатай орлоготой амьдарч байна. Энэ нь ядуурлаас хамгаалах чухал бодлого юм шүү. Хүн бүр өтөлж хөгширсөн хойноо юмуу өвчин зовлон тохиолдсон үед хэрэглэх мөнгөө өөрөө хадгалж хуримтлуулаад байх боломжгүй.
- Мэдээж нийгмийн даатгал бол ашгийн төлөө бус гэдгээрээ бас ялгагдана. Бас даатгал гэдэг утгаараа эрсдэлийг удирдах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлд их анхаарч байна. Зөвхөн нөхөн төлбөр олгоход бус тухайн эрсдэл тохиолдохоос сэргийлэх нь даатгуулагч, даатгагч, нийгэмд бүгдэд нь хэрэгтэй.

Баярлалаа, танд. Бид хоёр таны өгсөн материалуудыг уншиж судална аа.







Өвөө! Бид хоёр нийгмийн даатгалын хэлтэст очоод зөндөө их мэдээлэл авлаа. Бас нэлээд юм ойлгож авлаа. Манай гэрийнхэн чинь бүгдээрээ даатгуулсан, түүнийхээ үр шимийг ямар нэг байдлаар хүртэж байдаг хүмүүс юм байна шүү.

Тиймээ, гэхдээ эмээ нь нийгмийн даатгалаас тэтгэвэр авдаггүйг мэдэх үү, та хоёр?


Үгүй. Эмээгийнх өөр тэтгэвэр юм уу? Бас л сар болгон авдаг шүү дээ. Гэхдээ эмээгийн тэтгэвэр таныхаас бага байх аа.




Тиймээ. Эмээ нь залуудаа үр хүүхдээ өсгөх, аав ээждээ туслах гэх мэт шалтгаанаар цалин, орлоготой ажил харьцангуй цөөн жил хийсэн. Тэгээд нийгмийн даатгалаас тэтгэвэр авах болзлыг хангаагүй учир нийгмийн халамжийн тэтгэвэр авдаг юм. Өвөөгийн чинь авдагтай жишвэл хамаагүй бага. Гэсэн ч төрийн буян, яахав хөөрхий. Харин та нартаа захихад ажил хийж орлого олж л байвал нийгмийн даатгалд шимтгэл төлж байгаарай. Насны эцэст хэрэгтэй юм байна.



Аан,
эмээ бага тэтгэвэртэй
гээд байдаг нь ийм учиртай байх
нь. Халамжийн тэтгэврийг дан улсын
төсвөөс олгодог болохоор өндөр байж
чадахгүй байх л даа. Ажил хийж орлого
олж л байвал нийгмийн даатгалд
хамрагдаарай гэсэн эмээгийн үгийг
мартахгүй ээ.



Зүгээр
даатгуулаад л болчих юм
биш. Харин нийгмийн даатгалын
шимтгэлээ аль болох л олон жил
тасралтгүй төлөх нь эргээд авах тэтгэвэр,
тэтгэмжийн хэмжээнд нөлөөлдөг юм байна.
Оюутнууд бид энэ талаар маш бага мэддэг
мөртлөө ёстой мэдэмхийрч өгдөг байх нь. Эртээр
манай ангийн Тэмүүлэн мөнгөтэй болчихвол
нийгмийн даатгалаар яах юм. Мөнгөө
банкинд хадгалуулчихад л болно шүү
дээ гээд маргаад байсан. Арай ч
тийм биш юм аа.




Өвөө,
эртээр манай
ангийнхан хадгаламж,
нийгмийн даатгал хоёрын аль
нь илүү ашигтай вэ гэж бяцхан
маргаад. Манай ангийн Тэмүүлэн
нийгмийн даатгалд төлөх мөнгөө
банкинд хадгалуул. Хүүгээрээ өсөөд
хамаагүй ашигтай гээд, манайхны
зарим нь дэмжээд байсан. Та
байсан бол алийг нь дэмжих
вэ?

Миний бодлоор, та нар хоёр өөр
юмыг харьцуулаад байгаа юм биш үү?
Хадгаламж хүнд хэрэгтэй. Одооноос
эхлээд мөнгөө гамтай хэрэглэж, бага ч
гэсэн хадгаламжтай болох нь залуус та
нарт чухал. Гэхдээ хадгаламж нийгмийн
даатгалыг орлож чадахгүй.

Цацрал: Яагаад, өвөө?

Эмээ, өвөө хоёр нь хэдэн төгрөгийн хадгаламжтай
байсан. Аав, ээж хоёрыг чинь гэрлэхэд, та нарыг
төрөхөд, чамайг дээд сургуульд ороход, аавыг
чинь ажлын тоног төхөөрөмж авахад бага багаар
зарцуулсаар одоо бараг дууссан. Хэрвээ би
хадгаламжиндаа найдаад нийгмийн даатгалд
даатгуулаагүй бол юун сар бүр тогтмол тэтгэвэр авах.
Аав, ээжийн чинь гарыг л харж суугаа байх. Тэгэхээр
хадгаламж, нийгмийн даатгал хоёрын аль аль нь
хүний амьдралд хэрэгтэй байгаа биз?



Нийгмийн
даатгалын эгч
бас хүн бүр хангалттай
хуримтлал хийх боломжгүй гэж
хэлээд байсан шүү. Би ажилд орж,
цалин авдаг болохоороо нийгмийн
даатгалд ч даатгуулна, бас мөнгөө
зөв зарцуулаад илүү гарсныг нь
банкинд хадгалуулна.

Миний охины зөв өө. Нийгмийн
даатгалдаа ч хамрагдаад, боломж
гарвал хадгаламжаа хийгээд байх
хэрэгтэй. Гэнэт их хэмжээний мөнгө
шаардагдах үед хадгаламж хэрэг
болдог юм шүү. Одоо хүмүүс орон
сууцны урьдчилгаа төлнө гээд сандраад
байх юм. Миний хүүхдүүд хадгаламж
хийж байвал орон сууц авах үед чинь
хэрэгтэй л байх.


Өнөөдөр Цацрал бид хоёр их зүйл мэдэж авлаа. Нийгмийн даатгалын ажилтнаас, өвөө, эмээ, ааваасаа зөндөө олон зүйлсийг бодит жишээн дээр яриулж маш сайн ойлголоо. Аливаа юмыг өөрийн хэмжээнд өнгөц ойлгож болохгүй юм байна. Мэдсэнээ найзууддаа хэлж өгч буруу ойлголтоо засах хэрэгтэй юм байна. Одоо ч нийгмийн даатгалын талаар найзуудтайгаа маргаж чадна шүү.

Би ч гэсэн найзуудтайгаа мэдсэнээ хуваалцана аа. Тэд нар миний яриаг сонсоод ёстой ангайна даа. Тэгээд хаанаас ийм юм мэдээд авчихав гээд шалгаах байх. Тэгэхээр нь нийгмийн даатгалын цахим хуудас, лавлах утасны дугаарыг өгчихнө дөө. Ахаа, та тэмдэглэж авсан уу?


Нийгмийн даатгалын цахим хуудас: www.ndaatgal.mn
Нийгмийн даатгалын үйлчилгээний лавлах утас: 1800-1289
Мессежтэй лавлах: 1900-1199

Өө, баярлалаа. Ах нь энийг чинь утсандаа тэмдэглээд авчихъя. Найзуудад маань ч хэрэг болно.


Миний хүүхдүүд сайн байна. Хэрэгтэй мэдээллийг цаг тухайд нь олж авна гэдэг хүний амьдралд маш чухал шүү. Хүн зөв мэдээлэлд үндэслэж байж л зөв шийдвэр гаргана.



Тэмдэглэл



Тэмдэглэл



БУЛГАН, ЦАЦРАЛ ХОЁР НИЙГМИЙН ДААТГАЛТАЙ ТАНИЛЦСАН НЬ
(Оюутан, сурагчдад зориулав)

Ерөнхий редактор

Боловсруулсан:

Хянан тохиолдуулсан:

Зураач, дизайнер:

Д.Мэндбаяр

Ө.Бодьгэрэл, А.Лхагвадэмбэрэл

Б.Батбаатар, Н.Аюуш

М.Ариунболд

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

Улаанбаатар хот 15160

Чингэлтэй дүүрэг

4-р хороо Бага тойруу 13/1

Утас: 976-11- 328030

Нийгмийн даатгалын үйлчилгээний лавлах утас: 1800-1289

Мессежтэй лавлах: 1900-1199